

**ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДАХИН ЗАГВАРЧЛАЛЫН ХЭЛТСИЙН ҮНДСЭН СИСТЕМ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ
Б.ОТГОНБАЯРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | | |
|---|---|--|---------------------|-----------------|---|---------|--------------------------------|------------------------|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | | |
| Зорилт 1. “Төрийн байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшилийг нэвтрүүлэх, бизнес процессын дахин инженерчлэл үзүүлэх” (Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт 39)-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт | | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Төрийн мэдээлэл солилцооны систем (ХҮР)-ийг тархсан бүтцэд шилжүүлнэ. | Тархмал бүтцэд шилжсэн мэдээлэл хариуцагч байгууллагын тоо | 0 | 3 | - “Ухаалаг засаг 2 төсөл” -ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 2.2.2.2-т заасан “Бие даасан техникийн зөвлөх/ХҮР систем”-ийн зөвлөх сонгон шалгаруулж, 2025 оны 04 сарын 04-ний өдрийн №2222 дугаартай гэрээ байгуулгадсан. - “Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем (ХҮР)-ийг тархсан бүтэц шилжүүлэх” зөвлөх үйлчилгээний ажлын явц болон гүйцэтгэгчийн тайланг хянан баталгаажуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тушаалтын төсөл /бүрэлдэхүүн, удирдамж/-ийг мэдээллийн технологийн төсөл, хөтөлбөр хариуцсан ахлах мэргэжилтний хамт боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/188 дугаар тушаалаар батлуулсан. - “Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем (ХҮР)-ийг тархсан бүтэц шилжүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлэхэд мэргжил арга зүйн дэмжлэг үзүүлэх | 01 - 12 | 30 | |

| | | | | | | | | |
|---|--|--|---|----|--|---|----|--|
| | | | | | | техникийн зөвлөх И-Монгол академи УТҮГ, Үндэсний дата төв УТҮГ дээр биечлэн ажиллаж, ажлын даалгаврыг боловсронгуй болгох, харьцуулсан судалгааны ажил тус тус хийгдэж байна. | | |
| Зорилт 2. “Цахим засаглалыг хөгжүүлэх, нэвтрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах” арга хэмжээний биелэлт | | | | | | | | |
| 2. | Арга хэмжээ 2.1. Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-д нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | 1 | 1 | “Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем (ХҮР)-ийг тархсан бүтэц шилжүүлэх” зөвлөхийн бэлтгэсэн санал, зөвлөмжийг үндэслэн III-IV улиралд шаардлагатай өөрчлөлт оруулах төслийг боловсруулахаар төлөвлөсөн. | 01-12 | - | |
| Зорилт 3. “Төрийн байгууллагуудын мэдээллийн сан, мэдээллийн систем, нээлттэй өгөгдлийг уялдуулах, нийтийн түлхүүрийн дэд бүтцийн тогтолцоо, нийтийн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх, зохион байгуулах, зохицуулах” | | | | | | | | |
| 3. | Арга хэмжээ 3.1. Суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн бүртгэл хөтөлнө. (Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээ 56) | Бүртгэсэн мэдээллийн сангийн тоо | 0 | 45 | Төрийн мэдээллийн систем, өгөгдлийн сангийн бүртгэл, дүгнэлт зөвлөмжийн системийг хэрэглээнд нэвтрүүлсний дараа III-IV улиралд бүртгэл хөтлөх үйл ажиллагааг цахимаар зохион байгуулахаар төлөвлөсөн. | 07 - 12 | - | |
| 4. | Арга хэмжээ 3.2. Нийтийн мэдээллийн сангийн өгөгдлийг их өгөгдлийн санд нэгтгэнэ (Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээ 57) | Их өгөгдлийн (big data) сан үүсгэх гүйцэтгэлийн хувиар | 0 | 5 | Их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий Ажлын хэсэг (Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын тушаал (2024.11.15, A/51/)-ийн хүрээнд: - Хүний хувийн мэдээлэлд хамаарах 35 төрлийн мэдээлэл, хуулийн этгээдэд | 01-06 | 90 | |

хамаарах 14 төрлийн мэдээллийг тодорхойлох боломжгүй болгох арга, аргачлалын хамт И-Монгол академи УТҮГ-т хүргүүлсэн.

- Нийгмийн даатгалын мэдээллийн сан, Нийгмийн халамжийн мэдээллийн сан, Хүн амын өрхийн мэдээллийн сан, Мал тооллогын мэдээллийн сан, Бизнес регистрийн мэдээллийн сангийн мета-өгөгдлийг тус тус мэдээлэл хариуцагчдаас гаргуулан авах, меташинжилгээ хийх ажлыг зохион байгуулсан.

- Өгөгдлийг 5 төрөл (Hashed keys, Masking, Obfuscation, Generalization, Perturbation) – өөр тодорхойлох боломжгүй болгон хувиргах хэрэгсэл, хувиргасан өгөгдлийг нууцлалтайгаар ХҮР системээр дамжуулах сервисийг тус тус хөгжүүлж дууссан бөгөөд хөдөлмөр, халамж, статистик, даатгалын мэдээллийн сан хариуцсан З байгууллагад туршилтаар суурилуулж, заавар гарын авлагаар хангаж ажилласан.

- “И-Монгол академи” УТҮГ-ын төлөөлөлтэй хамтран Үндэсний статистикийн хороо, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Мэдээллийн технологийн төв дээр 2025 оны 05 сарын 27-28-ны өдрүүдэд ажиллаж, өгөгдлийг хувиргах, нууцлан дамжуулах явцад гарсан эх кодын алдааг засварлах, турших ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- Нийтийн мэдээллийн сангийн өгөгдлийг их өгөгдлийн санд нэгтгэх дэд бүтцийг бэлдэх ажлын хүрээнд

| | | | | | | | |
|----|---|----------------------------|----|----|--|-------|----|
| | | | | | Үндэсний дата төв дээр 500GB санах ой бүхий нөөцийг үүсгэсэн. | | |
| 5. | Арга хэмжээ 3.3. Нийтийн мэдээллийн сангийн өгөгдлийг их өгөгдлийн санд нэгтгэх платформ хөгжүүлнэ. | Нэвтрүүлсэн платформын тоо | 0 | 1 | <ul style="list-style-type: none"> - "Нийтийн мэдээллийн сангийн өгөгдлийг их өгөгдлийн санд нэгтгэх платформ хөгжүүлэх" арга хэмжээг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах төсвийн тооцоог гаргасан. - "Нийтийн мэдээллийн сангийн өгөгдлийг их өгөгдлийн санд нэгтгэх платформ хөгжүүлэх" ажлын даалгаврыг боловсруулсан. | 04-12 | 30 |
| 6. | Арга хэмжээ 3.4. Сэлгэн ажиллах /high availability/ дата төвийн тоног төхөөрөмжийн нөөцийг бий болгоно (Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээ 60) | Хэрэгжилтийн хувь | 0 | 50 | Үндэсний дата төв УТҮГ-аас Сэлгэн ажиллах нөөц төвд шаардлагатай сервер, сүлжээ, хадгалах төхөөрөмж зэрэг 10 төрлийн нийт 128 ширхэг техник хэрэгслийн техникийн тодорхойлолтыг боловсруулсан ирүүлсний дагуу "Сэлгэн ажиллах дата төвийн нөөцийн тоног төхөөрөмж нийлүүлэх" ЦХИХХЯ/20250102135 дугаар бүхий худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. | 01-12 | 50 |
| 7. | Арга хэмжээ 3.5. Үндэсний дата төвийн үндсэн болон нөөц төвийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ. | Хүчин чадал, хувиар | 50 | 75 | Үндэсний дата төв УТҮГ-аас дата төвийн үндсэн болон нөөц төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн тоног төхөөрөмж, программ хангамж, мэдээллийн аюулгүй байдлын 20 төрлийн нийт 102 ширхэг техник хэрэгслийн техникийн тодорхойлолтыг боловсруулсан ирүүлсний дагуу "Ухаалаг засаг 2 төсөл"-ийн хурээнд | 01-12 | 50 |

| | | | | | | | |
|----|---|----------------------------------|-----|-----|---|-------|----|
| | | | | | "Үндэсний дата төвийн үндсэн болон нөөц төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэх" 2.2.1.1 дугаартай төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, үнэлэх ажил хийгдэж байна. | | |
| 8. | Арга хэмжээ 3.6. Төрийн мэдээллийн систем, өгөгдлийн сангийн бүртгэл, дүгнэлт зөвлөмжийн систем хөгжүүлнэ (Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээ 66) | Нэвтрүүлсэн хувилбар | 1.0 | 2.0 | <ul style="list-style-type: none"> - "Төрийн мэдээллийн систем, өгөгдлийн сангийн бүртгэл, дүгнэлт, зөвлөмжийн систем хөгжүүлэх" арга хэмжээг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах төсвийн тооцоог гаргасан. - Дүгнэлт, зөвлөмжийн системийг суурь болон тэрэлжсэн мэдээллийн сангийн бүртгэлтэй нэгтгэн "Төрийн мэдээллийн систем, өгөгдлийн сангийн бүртгэл, дүгнэлт зөвлөмжийн систем хөгжүүлэх" ажлын даалгаврыг боловсруулсан. - "Төрийн мэдээллийн систем, өгөгдлийн сангийн бүртгэл, дүгнэлт зөвлөмжийн систем хөгжүүлэх" ЦХИХХЯ/20250103043 дугаартай тендерийн худалдан авах ажиллагааг Үнэлгээний хороо зохион байгуулж байна. | 01-12 | 30 |
| 9. | Арга хэмжээ 3.7. Олон улсын дата төвийн зах зээлийн судалгаа хийж, дата төвийн зах зээлд өрсөлдөх үндэсний стратегийг боловсруулна (Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээ 44) | Боловсруулсан баримт бичгийн тоо | 0 | 1 | - "Олон улсын дата төвийн зах зээлийн судалгаа хийж, дата төвийн зах зээлд өрсөлдөх үндэсний стратегийг боловсруулах" арга хэмжээг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах төсвийн тооцоог гаргасан. | 01-12 | 50 |

| | | | | | | | |
|-----|--|---------------------|---|---|---|-------|----|
| | | | | | - Олон улсын дата төвийн зах зээлийн судалгаа хийж, дата төвийн зах зээлд өрсөлдөх үндэсний стратегийг боловсруулах" судалгааны ажлын даалгаврыг боловсруулсан. | | |
| 10. | Арга хэмжээ 3.8. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн ногоон дата төв байгуулах төслийн санал боловсруулна (Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээ 67) | Төслийн саналын тоо | 0 | 1 | - Олон улсын дата төвийн зах зээлийн судалгаа хийж, дата төвийн зах зээлд өрсөлдөх үндэсний стратегийг боловсруулах" судалгааны ажлын даалгаварт ногоон дата төв байгуулах нөхцөл боломжийн талаар тусгасан бөгөөд судалгааны үр дүнд үндэслэн санал боловсруулахаар төлөвлөсөн. | 01-12 | 50 |
| 11. | Арга хэмжээ 3.9. Их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай систем, техник хэрэгслийн тооцоо, судалгаа хийнэ (Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээ 98) | Судалгааны тоо | 0 | 1 | <ul style="list-style-type: none"> - "Их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай систем, техник хэрэгслийн тооцоо, судалгаа хийх" арга хэмжээг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах төсвийн тооцоог гаргасан. - "Их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай систем, техник хэрэгслийн тооцоо, судалгаа хийх" ажлын даалгаврыг боловсруулсан. - "Их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай систем, техник хэрэгслийн тооцоо, хүний нөөцийн тооцоо судалгаа хийх" ЦХИХХЯ/20250203042 дугаартай үйлчилгээний тендерт шалгарсан Бидсолюшн ХХК-тай гэрээ байгуулах эрх олгох тушаалын төсөл, гэрээний | 01-06 | 70 |

| | | | | | | | |
|---|---|--|---|---------------|--|---------|-----|
| | | | | | төслийг тус тус боловсруулж, хяналтын шатанд шилжүүлсэн. | | |
| Зорилт 4. “Цахим орчинд харилцаа холбоо, мэдээллийн технологийн зөв зохистой хэрэглээний соёлыг нэвтрүүлэх, бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэн, тоон хуваагдлыг бууруулах, иргэдийн мэдээлэл авах хүртээмжийг нэмэгдүүлэх” | | | | | | | |
| 12. | Арга хэмжээ 4.1. Нээлттэй өгөгдөл, их өгөгдлийн чиглэлээр төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулна. | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | 0 | 100 | Нийтийн мэдээллийн сангийн өгөгдлийг их өгөгдлийн санд нэгтгэх туршилт, нийтийн мэдээллийн сангийн өгөгдлийг их өгөгдлийн санд нэгтгэх платформыг хэрэглээнд нэвтрүүлсний дараа III-IV улиралд сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн. | 09-12 | - |
| ХОЁР. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” зорилтын хүрээнд | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, дээд шатны удирдлагаар баталгаажуулах, үр дүнг хуульд заасан хугацаанд тайлагнах | Төлөвлөгөө, тайлан | 0 | Хэрэгжил тээр | - Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1-р улиралд батлуулсан. - Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 7 хоног, сар, I, II улирлаар тайлагнасан. | 01 -06 | 100 |
| 2. | Арга хэмжээ 2. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хөтлөх нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг хугацаанд нь бүрэн архивлах | Архивд хүлээлгэсэн өгсөн баримт бичгийн тоо | 0 | Хэрэгжил тээр | - Тайлант хугацаанд албан бичиг: - Ирсэн бичиг - 6, - Явуулсан /шийдвэрлэсэн/ - 8 | 01-06 | 100 |
| 3. | Арга хэмжээ 3. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэх | Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоо | 0 | Хэрэгжил тээр | - Үндсэн болон дэмжих системд холбогдох, сервис үйлчилгээ авах, алдаа тасалдал гарсан талаарх иргэн, хуулийн этгээдийн нийт 25 хүсэлтэд зөвлөгөө, мэдээллийг өгсөн байна. | 01 - 06 | 100 |
| 4. | Арга хэмжээ 4. | Мэдүүлэг | - | Хуульд заасан | ХАСХОМ-ыг 2025.01.15-нд мэдүүлсэн. | 01 | 100 |

| | | | | | | | |
|----|---|---------------------------------|---|---------------------------|---|---------|-----|
| | Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ) болон ХАСХУМ мэдүүлэх | | | хугацаанд мэдүүлсэн байна | | | |
| 5. | Арга хэмжээ 5. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | 0 | Хэрэгжил тээр | Албан үргийн дагуу шийдвэрийн төсөл боловсруулах, төрийн байгууллага болон хүн хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэхдээ Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг мөрдөж ажилласан. | 01 - 06 | 100 |

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН БИЕЛЭЛТ

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|-----|--|---------------------|-----------------|-----------------|--|--------------------------------|------------------------|
| 1 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн биелэлт, Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын биелэлт, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хэрэгжилт | Тайлан | 0 | 12 | <ul style="list-style-type: none"> - Төрийн үйлчилгээний дахин загварчлалын хэлтэст хамаарах хууль тогтоомжийн биелэлтийг 1-5 сарын хугацаанд сар тутам гаргасан. - “Монгол Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар “Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолын биелэлт, Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Алсын хараа-2050, Шинэ сэргэлт бодлого, Засгийн газрын 2020-2024 оны биелэлтийн эрчимжүүлэх шаардлагатай ажлын гүйцэтгэлийн хэрэгжилтийн биелэлтийг тус тус гаргасан. - Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2022-2024 оны стратеги | 01 - 06 | 100 |

| | | | | | | | |
|----|--|----------------------|---|--------------|--|-------|-----|
| | | | | | tөлөвлөгөө, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан нийтийн мэдээллийн дэд бүтцэд хамаарах арга хэмжээний биелэлтийг тус тус гаргаж, "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт"-ийн нотлох баримтуудыг бэлтгэн, хариуцсан албан хаагчид хүргүүлсэн. - Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний стратеги төлөвлөгөөний төсөлд хэлтсийн чиг үүрэгт хамаарах санал боловсруулж, тусгасан. - Засгийн газрын 2025 оны 100 хоногийн төлөвлөгөөний биелэлтийг хариуцсан чиг үүргийн дагуу гаргасан. | | |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Ажлын хэсэг | Оролцсон ажлын хэсэг | 0 | Хэрэгжилтээр | - Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги боловсруулах ажлын хурээнд төрийн байгууллагын төлөөлөл (13 яам, 19 агентлагийн нийт 52 албан хаагчид), банк санхүүгийн төлөөлөл (11 арилжааны банк, финтекийн холбооны 12 гишүүд), үүрэн холбооны оператор компаниудын төлөөлөлтэй санал солилцох 3 удаагийн уулзалтад нийтийн мэдээллийн дэд бүтэц, их өгөгдлийн талаар мэдээлэл өгч оролцсон. - Мөн Өгөгдөл (их өгөгдөл, нээлттэй өгөгдөл, нээлттэй мэдээлэл) – | 01-06 | 100 |

ийн талаар хэвлэлийн мэдээ, их өгөгдлийн талаар сайдын хэлэх үг, танилцуулга бэлтгэсэн.

- "Ухаалаг засаг-2 төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 1.1.3 д заасан "Цахим шилжилтийг хийхэд шаардлагатай дүрэм журмуудын хийдэл, зөрчлийг тогтоож, санал боловсруулах зевлэх үйлчилгээ тесөл"-ийн гэрээт ажлын явц болон гүйцэтгэлийн тайланг хянан баталгаажуулах" үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж, гүйцэтгэгчийн ирүүлсэн нарийвчилсан төлөвлөгөө, олон улсын шилдэг туршлагын судалгааны тайлан, зөрүүгийн шинжилгээний аргачлал, дүрэм, журмын жагсаалт бүхий баримт бичгүүдтэй танилцаан, өөрчлөлт оруулах шаардлагатай агуулгуудад санал боловсруулж хүргүүлсэн.

- Инновац, цахим бодлогын байнгын хорооны тогтоолоор батлагдсан "Хилийн чанад дахь Монгол иргэдэд төрийн үйлчилгээний нэгдсэн "И-Монголиа" системийг хүртээмжтэй болгох, цахимаар сонгуульд оролцох эрхийг хангах боломжийг судлан, дүгнэлт гаргах" үүрэг бүхий ажлын хэсгийн 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн уулзалтад оролцож, төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, нийтийн мэдээллийн дэд бүтцийн бэлэн байдал, тоон гарын үсгийн дэд бүтцийн шинэчлэл, гадаад улс оронд төрийн үйлчилгээг хүргэж байгаа талаарх мэдээллийг танилцуулсан.

| | | | | | | | |
|----|---|-------------|---|--------------|--|-------|-----|
| | | | | | - Сонгуулийн ерөнхий хорооны 2025 оны 4 сарын 30-ны өдрийн №3 дугаар тогтоолоор байгуулагдсан “Сонгуулийн автоматжуулсан системд ашиглах программ хангамж, техник хэрэгслийн ажиллагааг шалган туршиж, баталгаажуулан гэрчилгээ олгох” үүрэг бүхий Ажлын хэсгийн хүрээнд батлагдсан төлөвлөгөөний дагуу сонгогчдын бүртгэлийн программ хангамжийн эх кодыг шалган баталгаажуулж, гэрчилгээжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. | | |
| 3. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Шийдвэрийн төсөлд санал өгөх | Саналын тоо | 0 | Хэрэгжилтээр | <p>- Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 02 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах тухай Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн албан бичиг (2025.01.29, ХЭГ/289)-ийн дагуу Улсын нэгдсэн төсвийн ангилалд Мэдээллийн технологийн арга хэмжээ, кибер аюулгүй байдлын ангиллын зардлыг шинээр нэмж тус бүрд программ хангамж, техник хангамжаар ялган “Зардлын эдийн засгийн ангилал”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал боловсруулж, 2025.02.28-ны өдрийн 01/518 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>- Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооноос ирүүлсэн хуулийн хэрэгжилтийг ханггуулах тухай албан бичиг (2025.02.13, УИХ-08/2049) - ийн дагуу Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн</p> | 01-06 | 100 |

| | | | | | |
|--|--|--|--|---|--|
| | | | | <p>хэрэгжилтийн талаарх мэдээллийг бэлтгэж, хүргүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн албан зөвлөлөөс ирүүлсэн хамтран ажиллах тухай албан бичиг (2025.03.10, 02/553, 2025.05.06, 02/1041) - ийн дагуу "Үндэсний дата төв" дээр байрлах цахим системийн хэвийн, аюулгүй ажиллагааг хангах талаар мэдээллийг бэлтгэж Үндэсний дата төв УТҮГ-т хүргүүлсэн. - Инновац, цахим бодлогын байнгын хорооны тогтоолоор батлагдсан "Хилийн чанад дахь Монгол иргэдэд төрийн үйлчилгээний нэгдсэн "И-Монголиа" системийг хүртээмжтэй болгох, цахимаар сонгуульд оролцох эрхийг хангах боломжийг судлан, дүгнэлт гаргах" үүрэг бүхий Ажлын хэсгээс гадаадад амьдарч буй монгол иргэдийн саналыг цахимаар авах, санал авах үйл ажиллагаанд дэмжих систем ашиглах эсэх талаар саналыг албан бичгээр ирүүлэх үүрэг өгсний дагуу холбогдох саналыг бэлтгэж хяналтад шилжүүлсэн. - Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас албан бичиг (2025.05.06, ХЭГ/1298) - ээр ирүүлсэн "Тооллого явуулахад дэмжлэг үзүүлэх тухай", "Аж ахуйн нэгжийн тооллого явуулах тухай" Засгийн газрын тогтоолын төслийд тэслүүдтэй танилцаж, санал боловсруулан 2025 оны 05 сарын 21-ний өдрийн 01/1210 дугаар албан бичгээр хүргүүлсэн. - "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан мод бүрийг бүртгэлжүүлэх, хяналт, урамшууллын | |
|--|--|--|--|---|--|

| | | | | | | | |
|--|--|-------------------------|---|--------------|---|-------|-----|
| | | | | | үйл ажиллагааг төрийн үйлчилгээний нэгдсэн "И-Монголиа" системд нэгтгэх талаар хууль, дүрэм журмын зохицуулалтыг судалж, санал боловсруулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Ойн газар, И-Монгол УТҮГ-ын хамтарсан уулзалтад танилцуулсан. | | |
| | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. Мэдээлэл хариуцагчаас ирүүлсэн нийтийн мэдээллийн системд зөвлөмж, дүгнэлт өгөх | Дүгнэлт, зөвлөмжийн тоо | 0 | Хэрэгжилтээр | <ul style="list-style-type: none"> - Ашигт малтмал, газрын тосны газраас зөвлөмж, дүгнэлт гаргуулахаар 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 01/5088 дугаартай албан бичгээр ирүүлсэн "Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үлдэгдэл, үнэ болон борлуулалтын мэдээ, мэдээллийн систем (petro.smartsolution.mn)"-ийн ажлын даалгавар, бусад холбогдох баримт бичгийг судалж, хариуцсан чиг үүргийн дагуу зөвлөмж, дүгнэлтийг боловсруулан, систем (https://isr.gov.mn)-д оруулсан. - Үндэсний статистикийн хорооноос зөвлөмж, дүгнэлт гаргуулахаар 2024 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 07/889 дугаартай албан бичгээр ирүүлсэн "Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн систем"-ийг шинэчлэн хөгжүүлэх ажлын даалгавар, холбогдох баримт бичигтэй танилцан, хариуцсан чиг үүргийн дагуу зөвлөмж, дүгнэлтийг боловсруулсан. - Хууль зүйн туслалцааны төвөөс санал авахаар 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01/70 дугаартай албан бичгээр ирүүлсэн "Хиймэл оюунд суурилсан хууль зүйн зөвлөгөө | 01-06 | 100 |

| | | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|--|
| | | | | | өгөх систем"-ийн ажлын даалгавартай танилцан холбогдох баримт бичгийг судалж, саналыг албан бичиг (2025.02.18, 03/367)-ээр хүргүүлсэн. | | |
|--|--|--|--|--|--|--|--|

ГУРАВ. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур Үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|-----|---|---------------------|---------------------|-----------------|---|----------|--------------------------------|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | Эхэлсэн, дууссан хугацаа |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | |
| 1. | Арга хэмжээ 1. Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх АЗ сургалтад хамрагдах. | Сертификатын тоо | 0 | 1 | Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх АЗ сургалтад 2025 оны 01 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд хамрагдсан. 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр шалгалт өгсөн. | 1 улирал | 80 |

| | | | | | | | |
|----|---|------------------------|---|---|---|---------|-----|
| 2. | Арга хэмжээ 2. Эрхэлсэн ажлын чиглэлээр олон улсаас зохион байгуулагдах сургалт, хурал, семинарт оролцох | Сургалт, семинарын тоо | 0 | 2 | <ul style="list-style-type: none"> - Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2025 оны 01 сарын 28-ны өдөр зохион байгуулсан “Цахим эрх зүй, түүний хөгжлийн чиг, хандлага” олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцсон. - Гаалийн ерөнхий газраас 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан “Хиймэл оюунд суурилсан дэвшилтэд технологийг нэвтрүүлж, гаалийн шинэчлэлийг бэхжүүлэх төсөл”-ийн уулзалтад оролцсон. | 01 - 06 | 100 |
| 3. | Арга хэмжээ 3. Байгууллагаас зохион байгуулах сургалт, арга хэмжээнд хамрагдах | Сургалт, хурал | 0 | 2 | <ul style="list-style-type: none"> - “Мэдээллийн технологи, хиймэл оюун ухааны хөгжлийн чиг хандлага” сэдэвт сургалтад 2025 оны 01 дүгээр 06-ний өдөр хамрагдсан - “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулсан мод тарих үйл ажиллагаанд 2024 оны 05 дугаар 21-ний өдөр оролцсон. | 01 - 06 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Үндсэн систем хариуцсан
шинжээч

(Албан тушаал)

Баатар овогтой Отгонбаяр
/ /

(Нэр, гарын үсэг)

2025 - 06 - 09 ..

(Огноо)